

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Харилцагч нь “ГҮҮДСЕК ҮЦК ХХК” /цаашид “ҮЦК” гэх/-ийн харилцагчдаа үзүүлэх цахим үйлчилгээг www.goodsec.mn цахим хуудас /цаашид “Вэбсайт” гэх/-аар дамжуулан авахдаа дор дурдсан нөхцөлүүдийг бүрэн ойлгож, хүлээн зөвшөөрсөн болно. Энэ нь “Цахим үйлчилгээний нөхцөл” /цаашид “Үйлчилгээний нөхцөл” гэх/-ийг бүрэн ойлгож, хүлээн зөвшөөрсөн, холбогдох гэрээг бичгээр байгуулсантай адилаар тооцогдоно.

НЭГ. НӨХЦӨЛҮҮД

- 1.2. Харилцагч нь энэхүү Үйлчилгээний нөхцөл”-ийг хүлээн зөвшөөрснөөр цаашид ҮЦК-ийн аливаа үйлчилгээг цахимаар авах буюу санхүүгийн гүйлгээ хийх, үнэт цаасны данс нээлгэх, үнэт цаас худалдах, худалдан авах захиалга гаргах болон бусад нэмэлт үйлчилгээг Вэбсайтаар авахдаа өөрт тухайлан олгогдсон, эсхүл өөрийн үүсгэсэн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглана.
- 1.3. Харилцагч нь Вэбсайтад ашиглах өөрийн нэвтрэх нэр, нууц үг, нэг удаагийн нууц үг, кодын нууцлалыг алдсан, бусдад задруулсан байж болзошгүй тохиолдолд ҮЦК-ийн салбар, харилцагчийн төв, утасны дугаарт яаралтай мэдэгдэх үүрэгтэй. Нууцлалыг алдсан, бусдад задруулсан, яаралтай мэдэгдээгүйгээс үүдэн гарах хохирлыг харилцагч бүрэн хариуцна.
- 1.4. ҮЦК нь харилцагчийн цахимаар, бичгээр гаргасан захиалга, гүйлгээний хүсэлт, өргөдлийг үндэслэн холбогдох захиалга, гүйлгээг гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, ҮЦК-ийн дотоод журамд заасны дагуу үйлчилгээний эрсдэлийг бууруулах зорилгоор захиалга, хүсэлтийг хянах, хязгаарлах эрхтэй.
- 1.5. Харилцагч нь энэхүү Үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрснөөр өөрийн мэдээллийг Зээлийн мэдээллийн сан, Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хууль, тогтоомжид заасан арга хэрэгслийн дагуу харах, хувилах эрхийг ҮЦК-д зөвшөөрсөн болно. Энэхүү зөвшөөрлийг Хувь хүний нууцын тухай хуульд заасан Харилцагчийн бичгээр гаргасан зөвшөөрөл гэж үзнэ.
- 1.6. ҮЦК нь өөрийн үйлчилгээний шимтгэл, хураамжид өөрчлөлт оруулсан тохиолдолд ажлын 3 өдрийн дотор Вэбсайтаар дамжуулан харилцагчид мэдээлнэ. Ийнхүү мэдээлснээс хойш хуанлийн 15 хоногийн дотор Харилцагчаас нөхцөлийг хүлээн зөвшөөрөхгүй тухай мэдэгдлийг ҮЦК-ийн салбар, харилцагчийн төв, утасны дугаарт мэдэгдээгүй тохиолдолд тухайн үйлчилгээний шимтгэл, хураамжийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 1.7. Харилцагч нь энэхүү Үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрснөөр дараах зөвшөөрлийг ҮЦК-д олгож байгаа болно. Үүнд:
 - 1.7.1. Харилцагч нь ҮЦК-ийн харилцан хамаарал бүхий этгээдээс үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг авахыг хүсвэл ҮЦК-д байрших өөрийн аливаа мэдээллийг тэдгээр этгээдэд дамжуулах;
 - 1.7.2. Харилцагчийн хувийн мэдээллийг хүлээн авч, мэдээллийн санд хадгалах;
 - 1.7.3. Харилцагчийн үнэт цаас, үнэт цаастай холбоотой бүхий төрлийн гүйлгээний мэдээллийг хүлээн авч, мэдээллийн санд хадгалах;
 - 1.7.4. Төрийн цахим мэдээллийн санд хандан харилцагчийн хувийн мэдээллийг гаргуулах, шалгах, баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл гаргуулах;

- 1.7.5. Шаардлагатай тохиолдолд Харилцагчийн хувийн мэдээллийг ашиглан хиймэл оюун ухаанд тусламжтай дүн шинжилгээ хийх, түүнд үндэслэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох;
- 1.8. ҮЦК нь харилцагчийн цахимаар, бичгээр гаргасан захиалга, гүйлгээний хүсэлт, өргөдлийг үндэслэн дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
 - 1.8.1. Үнэт цаасны данс нээх;
 - 1.8.2. Үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах;
 - 1.8.3. Үнэт цаасны арилжааны дүнд үүссэн төлбөр тооцоог төвлөрсөн хадгаламжийн данс, номинал дансаар дамжуулан гүйцэтгэх;
 - 1.8.4. Харилцагчийн захиалга, дансны мэдээлэл, лавлагаа, хуулга, тодорхойлолтыг гаргаж өгөх, харуулах;
 - 1.8.5. ҮЦК-ийн санал болгож буй бусад үйлчилгээг үзүүлэх;
- 1.9. Харилцагч нь энэхүү нөхцөлийн 1.7-д заасан үйлчилгээг цахим сувгаар хүлээн авсан нь ҮЦК-д биеэр ирж үйлчлүүлсэнтэй адил хүчин төгөлдөр байна.
- 1.10. Харилцагч нь Үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөх үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан ҮЦК -ийн үйлчилгээний шимтгэл, хураамжийг хүлээн зөвшөөрсөн болно.
- 1.11. Харилцагч нь үнэт цаасны данс нээлгэх хүсэлтээ цахим сувгаар ирүүлэн харилцагчийн улсын бүртгэлийн ҮЦК-аас шалтгаалахгүй алдаа, зөрүү илрээгүй, данс нээлгэх хураамж бүрэн төлөгдөж бүртгэгдсэн тохиолдолд тухайн данс нээлгэх хүсэлтийг ҮЦК нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад илгээнэ.
- 1.12. Харилцагч нь үнэт цаасны данс нээлгэх хүсэлтээ Вэбсайтад бүрэн бүртгүүлснээр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн гэрээгээ өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан Вэбсайтаас хэвлэн авах боломжтой;
- 1.13. ҮЦК нь харилцагч Вэбсайтад ашиглах нэвтрэх нэр, нууц үгээ мартсан тохиолдолд бүртгэлтэй утасны дугаар болон бусад мэдээллийг үндэслэн сэргээх, шинэчлэх боломжоор хангана.
- 1.14. ҮЦК нь Хувь хүний нууцын тухай хуульд заасны дагуу харилцагчийн хувийн мэдээлэл, санхүүгийн нууцыг чанд хадгалж, харилцагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй.
- 1.15. Харилцагч нь ҮЦК-д гаргаж өгсөн өөрийн аливаа мэдээлэлд өөрчлөлт орсноос хойш ажлын 5 өдрийн дотор ҮЦК-д мэдэгдэж мэдээллээ шинэчлүүлэх үүрэгтэй. Энэхүү үүргээ хэрэгжүүлээгүйгээс үүдэн учирсан хохирлыг харилцагч бүрэн хариуцна.
- 1.16. ҮЦК нь өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар харилцагчид үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.
- 1.17. ҮЦК нь энэхүү үйлчилгээний нөхцөл болон үйлчилгээний шимтгэл, хураамжид өөрийн санаачилгаар өөрчлөлт оруулах эрхтэй.
- 1.18. ҮЦК нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх арга хэмжээний хүрээнд харилцагчийн гүйлгээг зогсоох, дансыг царцаах, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, Вэбсайтад ашиглах нэвтрэх нэр, нууц үгийг хүчингүй болгох эрхтэй бөгөөд эрхээ хэрэгжүүлсэн тохиолдолд ажлын 3 хоногт багтаан тухайн харилцагчид бүртгэлтэй утасны дугаар эсхүл бүртгэлтэй и-мэйл хаягаар нь мэдэгдэнэ.
- 1.19. Харилцагч нь өөрийн үнэт цаасны данс, номинал данс, төлбөр тооцооны дансаар дамжуулан луйврын шинжтэй аливаа үйлдэл хийхээр завдсан, хийсэн болон сэжиг бүхий тохиолдолд ҮЦК нь тухайн харилцагчийн бүх гүйлгээг зогсоож хууль, хяналтын байгууллагад мэдэгдэнэ.
- 1.20. Харилцагч цахим сувгаар авсан үйлчилгээний хураамж, шимтгэлийг саадгүй төлнө. Шимтгэл хураамжийн төрлөөс шалтгаалан урьдчилан төлөх, суутгуулах гэсэн 2 хэлбэртэй байна.

- 1.21. ҮЦК нь харилцагчийг цахим сувгаар үйлчилгээ авах заавар аргачлалтай танилцах боломжоор хангана.
- 1.22. Цахим сувгаар үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэх явцад гарсан аливаа маргаан, үл ойлголцлыг талууд эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 1.23. Харилцагч нь цахим үйлчилгээтэй холбоотой гомдлыг ҮЦК-ийн удирдлагад бичгээр эсхүл цахим хэлбэрээр гаргаж болно. ҮЦК-ийн удирдлага гаргасан гомдолд хуанлийн 14 хоногийн дотор хариу өгнө.
- 1.24. Харилцагч 7 хоногийн бүх өдрүүдэд 24 цагийн турш шаардлагатай үедээ Вэбсайтыг ашиглан дараах үйлдлийг хийх эрхтэй байна. Үүнд:
 - 1.24.1. Дансны үлдэгдэл болон хуулга харах шалгах;
 - 1.24.2. Арилжааны захиалга өгөх;
 - 1.24.3. Арилжааны үнэ ханшийн мэдээллийг харах;
 - 1.24.4. ҮЦК-аас тогтоосон бусад;
- 1.25. ҮЦК нь арилжааны захиалгыг дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Хөрөнгийн биржийн арилжааны системд шивж оруулна. Үүнд:
 - 1.25.1. Харилцагчийн данс үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад нээгдсэн байх;
 - 1.25.2. Харилцагчийн захиалга нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;
 - 1.25.3. Захиалга гаргахын өмнө шаардлагатай мөнгөн хөрөнгө, үнэт цаас тухайн харилцагчийн дансанд байршсан байх;
 - 1.25.4. ҮЦК-аас тавих бусад шаардлагуудыг хангасан байх.
- 1.26. Монголын хөрөнгийн биржийн арилжааны төлбөр тооцоог Т+2 горимын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 1.27. Биржийн бус зах зээлийн арилжааны төлбөр тооцоог “Биржийн бус зах зээлийн арилжааны журам”-д заасны дагуу хийж гүйцэтгэнэ.
- 1.28. Энэхүү үйлчилгээний нөхцөлд дурдагдаагүй бусад бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой ҮЦК-аас тогтоосон нөхцөл, шаардлага, хязгаарлалтыг харилцагч тухай бүр хүлээн зөвшөөрч тухайн үйлчилгээг авна.

--ooOoo--